

НҮБ-ийн Ази, Номхон Далайн бүс нутгийн Эдийн Засаг-Нийгмийн Комиссын Зүүн болон Зүүн хойд Азийн оффис

НҮБ-ийн Ази, Номхон Далайн бүс нутгийн Эдийн Засаг-Нийгмийн Комиссын Зүүн болон Зүүн хойд Азийн оффис нь 2010 оны 5-р сарын 17-ны өдөр НҮБ-ийн Ерөнхий хуралдааны шийдвэрээр Солонгосын Инчеон хотын Сонгдод Хятад, Солонгос, Япон, Монгол, Хойд Солонгос, Оросын холбооны улс зэрэг гишүүн 6 орныг дэмжих зорилгоор анх байгуулагдсан. Ази, Номхон Далайн бүс нутгийн Эдийн Засаг-Нийгмийн Комиссын Зүүн болон Зүүн хойд Азийн оффис нь одоогийн байдлаар зөвхөн Хойд Азийн дээрх 6 орныг дэмжиж хамтран ажиллахаас гадна Зүүн Хойд Азийн Байгаль Орчны Хамтын Ажиллагааны Дэд Бүсийн Хэрэг Эрхлэх Газраар ажиллаж байна.

Ази, Номхон Далайн бүс нутгийн Эдийн Засаг-Нийгмийн Комиссын Зүүн болон Зүүн хойд Азийн оффис нь

- Комиссын ажлыг дэмжих
- Зүүн Хойд Азийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх
- НҮБ-н Хойд Азийн Бүсийн хөгжлийг удирдах
- Зүүн Хойд Азийн Байгаль Орчны Хамтын Ажиллагааны Дэд Бүсийн Хэрэг Эрхлэх Газрын үйл ажиллагааг эрхлэх зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Нийгмийн ялгааг арилгах

Хэдийгээр Зүүн Хойд Азийн бүс нутгийн улс орнуудын эдийн засаг нь сүүлийн жилүүдэд эрчимтэй өсч байгаа боловч, эдийн засаг, нийгмийн ялгаа, тэнцвэргүй байдал нэмэгдсээр байна. Бид нийгмийн бүхий л бүлгүүдийн хөгжлийг дэмжиж, гишүүн орнуудын сайн туршлагыг солилцуулж хамтран ажиллуулах тал дээр илүү анхаарч байна.

- Өндөр настан хүмүүстэй ажиллах
- Залуустай ажиллах
- Жендрийн тэгш эрхийг хангах
- ДОХ-той хүмүүстэй ажиллах зэрэгт анхаарлаа хандуулж байна.

Бүс нутаг хоорондын харилцааг сайжруулах

Зүүн Хойд Ази нь дэлхийн худалдааг тэргүүлдэг томоохон орнуудыг багтаадаг дэлхийн томоохон худалдааны бүс нутаг юм. Сүүлийн жилүүдэд дэд бүс нь томоохон худалдааны түнш улсуудтай хийж байгаа худалдааны эдийн засгийн уналттай нүүр тулгараад байгаа бөгөөд энэ нь гадны олон хүчин зүйлээс шалтгаалж байна. Энэхүү гадны хүчин зүйлсийн нөлөөллийг багасгахын тулд дэд бүс нь томоохон зах зээлийнхээ өсөлтийг тэнцвэрлүүлж, бүс нутаг хоорондын

худалдааг нэмэгдүүлэх шаардлагатай болж байна. Бид бүсийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхийн тулд бүсийн ба дэд бүсийн түвшин дэх худалдаа, хамтын ажиллагааг сайжруулахаар ажиллаж байна.

- Бүс нутаг хоорондын худалдааг дэмжих
- Ази номхон далайн дээгүүрх худалдааны замыг нэмэгдүүлэх
- Эдийн засгийн өсөлтийг дэмжих зэрэг ажлуудыг хийж байна.

Зүүн Хойд Азийн Байгаль Орчны Хамтын Ажиллагааны Дэд Бүсийн Хэрэг Эрхлэх Газраар дамжуулан байгаль орчны тогтвортой байдлыг нэмэгдүүлэх
1993 оноос эхлэн гишүүн 6 орон нь Зүүн Хойд Азийн Байгаль Орчны Хамтын Ажиллагааны Дэд Бүсийн Хэрэг Эрхлэх Газраас хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд хил дамнасан байгаль орчны асуудлыг шийдэх зорилгоор дараах ажлуудыг хийж байна. Үүнд:

- Хил дамнасан агаарын бохирдлыг арилгах
- Эко-үр ашигтай хамтын ажиллагааг бий болгох
- Хилийн бүс нутагт байгаль орчныг хамгаалах
- Элсэн шуурга, тоосжилтоос сэргийлэх

Байгалийн гамшигаас урдчилан сэргийлэх

Сүүлийн жилүүдэд хүний амь нас, эдийн засгийн асар их хохиролыг дагуулсан томоохон хэмжээний байгалийн гамшиг Зүүн болон Зүүн Хойд Азийн бүс нутагт тохиолдсон билээ. Манай гишүүн орнууд хоорондоо туршлага солилцож, засгийн газрууд нь байгалийн гамшигийн эрсдлийг багасгахад илүү анхаарч дараах ажлуудыг хийж байна.

- Зүүн Хойд Азийн Байгалийн гамшиг
- Байгалийн гамшигийн эрсдлийг багасгах

Хөгжлийн хамтын ажиллагааг бий болгох

Өнөөгийн хурдацтай хөгжиж байгаа дэлхийд хөгжлийн хамтын ажиллагаа нь зөвхөн үйлдвэржсэн, өндөр хөгжилтэй орнуудаас хөгжингүй орнуудад олгож байгаа тусламж санхүүжилтээр явагдаж байна. Хөгжлийн хамтын ажиллагааг хамгийн үр нөлөөтэйгээр засгийн газрууд, олон улсын байгууллагууд, донорууд, иргэний байгууллагууд, хувийн хэвшил, хувь нийлүүлэгч зэрэг нь хамтран ажилласнаар нэмэгдүүлдэг. Үүний тулд бид гишүүн орнуудынхаа хөгжлийг дэмжих зорилгоор дараах мянганы хөгжлийн зорилтыг тавьж ажиллаж байна.

- Гурвалсан хамтын ажиллагааг нэмэгдүүлэх
- Сонирхогч талуудын хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх
- Нийтийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бий болгох

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ази Номхон Далайн Нийгэм Эдийн Засгийн Комисс (ЭСКАП)

НҮБ-н Ази Номхон Далайн Бүсийн хөгжлийн хөтөлбөрийн гүйцэтгэгч энэхүү байгууллага нь 62 гишүүн орны засгийн газраас бүрдэх бөгөөд 1947 онд анх байгуулагдсан. НҮБ-н Ази Номхон Далайн Бүсийн хамгийн том байгууллага бөгөөд 600 гаруй ажилтай албан хаагчтай.

预览已结束，完整报告链接和二维码如下：

https://www.yunbaogao.cn/report/index/report?reportId=5_5746

